

МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН
АУДИТЫН ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГА

**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН
АУДИТЫН ДҮГНЭЛТ**

2026 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгсөн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Төсвийн байнгын хороонд тус тус хүргүүлэхийг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа)-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол)-т тус тус даалгасугай.

3.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа), Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд), Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа), Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан) нарт тус тус даалгасугай.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг хадгаламжийн нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа)-т үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН



АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ	8
Монгол Улсын 2026 оны төсөвт тодотгол хийх үндэслэл хангагдсан байна	8
Төсвийн тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангаагүй байна	9
Төсвийн тодотголыг улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан байна	10
Төсвийн тодотгол нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байна	11
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ОРЛОГО	12
ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ЗАРЛАГА	16
Төсвийн урсгал зардал	16
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал	21
ТАВ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	23
ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24
ДОЛОО. ДҮГНЭЛТ	26

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд төсвийн тусгай шаардлагын нийцлийг үнэлсэн байдал	9
Хүснэгт 2. Төсвийн тодотголд орж буй өөрчлөлтийн бодлогын нийцлийн үнэлгээ	10
Хүснэгт 3. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлт	12
Хүснэгт 4. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ	13
Хүснэгт 5. Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын орлого	14
Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын бус орлого	15
Хүснэгт 7. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн нийт зардлын үзүүлэлт	16
Хүснэгт 8. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын үзүүлэлт	16
Хүснэгт 9. Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлын харьцуулалт	17
Хүснэгт 10. Монгол Улсын 2026 оны цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын нэгдсэн төсвийн үзүүлэлт	17
Хүснэгт 11. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардлыг салбараар	18
Хүснэгт 12. Төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгох татаас	18
Хүснэгт 13. Урсгал шилжүүлгийн зардлын харьцуулсан дүн	20
Хүснэгт 14. Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалт	22
Хүснэгт 15. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд	23
Хүснэгт 16. Нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн тодотгол	24

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө	28
Хавсралт 2. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл	30
Хавсралт 3. Төсвийн ерөнхийлөн захирагчдын тодотгосон нийт зардал	31



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилго, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 12 дугаар зүйлийн 12.1-д заасан бүрэн эрх, УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилго	Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль эрх зүйн хүрээнд арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг хянаж, дүгнэлт өгөхөд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: • Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголыг үндэсний аюулгүй байдал болон улсын тогтвортой хөгжлийн бодлого, бодит шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх; • Төсвийн тодотгол нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасантай нийцсэн эсэх; • Төсвийн тодотгол нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцсэн эсэх; • Төсвийн тодотголын төслийг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн, чиг үүргийн өөрчлөлтөд нийцүүлж боловсруулсан эсэх; • Төсвийн орлого, зарлагын өөрчлөлт, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд хийсэн төсвийн зохицуулалтыг бодит шаардлага, тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөсөн эсэх; • Төсвийн тодотголыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх; • Төсвийн тодотголоор нэмж төлөвлөсөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, ач холбогдлоор эрэмбэлж, хууль болон эдийн засгийн үр өгөөжтэй байх шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх; • Төсвийн тодотголын төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцож, хуулийн шаардлагад нийцүүлж, төлөвлөсөн эсэх.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС-д нийцүүлэн батлуулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-3:2020 “Чанарын хяналт”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад холбогдох заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав. Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргалаа. Аудитад төсвийн тодотголыг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар



Аудитын хамарсан хүрээ	зүйлийн 23.1 дэх заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан шаардлагыг гол шалгуур болголоо. Аудитад Монгол Улсын нэгдсэн төсөв /улсын төсөв, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан, бусад тусгай сангууд /-ийн 2026 оны батлагдсан төсөв, 2026 оны 7 дугаар сарын байдлаарх төсвийн гүйцэтгэл /урьдчилсан/, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчид болон хөтөлбөрүүдэд орсон өөрчлөлт, үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд, улсын болон орон нутгийн төсвөөс бууруулсан хөтөлбөр, арга хэмжээний мэдээ, тооцоо холбогдох баримт, санхүү, төсвийн мэдээ, үндсэн үзүүлэлтийг хамруулан гүйцэтгэв.
Талуудын хүлээх үүрэг, хариуцлага	Засгийн газар нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд тухайн жилийн төсөвт тодотгол хийнэ. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22, 23 дугаар зүйл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5, 6, 7, 8 дугаар зүйлд заасан зарчим, тусгай шаардлагын дагуу, боловсруулж, төсөв, танилцуулгын хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй. Төрийн аудитын байгууллага Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төрөөс баримтлах хөгжлийн бодлого, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд дүгнэлт гаргах үүрэг хүлээнэ.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа нар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитын менежер С.Нацагдорж, Нийцлийн аудитын газрын аудитын менежер Н.Анхбаяр, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер М.Наранжаргал нар хэрэгжүүлж, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, Ж.Энхтуяа, Б.Долгоржав, аудитор Г.Оюунтөгөлдөр, Б.Батхишиг, Д.Батчимэг, Э.Булганчимэг, Ж.Мөнхбилгүүн, С.Болортуяа, С.Алтанхуяг, Б.Тэгшсүрэн, Тусгай чиг үүргийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор Ж.Бямбацогт, Ч.Мөнхбулган, Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Н.Өлзийханд, аудитор Б.Булган, Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор У.Оюунхүү, Ш.Дэлгэрмаа, аудитор Б.Идэрбалжинням, Б.Мөнх-Эрдэнэ, Д.Нямжаргал, М.Доржмаа, Б.Ууганбилэг нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хийж гүйцэтгэв.
Хүндрэл бэрхшээл	Төсвийн тодотголын төсөлд аудит хийж, дүгнэлт хүргүүлэх хугацааг жилийн төсвийн төсөлтэй адил тусгайлан тогтоогоогүйгээс аудитыг гүйцэтгэх цаг хугацаа хязгаарлагдмал байсан.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР
АМНАТ	АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР
БНХАУ	БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС
ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
НДС	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН
НДШ	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ
НЗДТГ	НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
НӨАТ	НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР
ОХУ	ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ТТБТХ	ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ
ТӨБЗГ	ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
ТЭЗҮ	ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ҮАБҮБ	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
ХАА	ХӨДӨӨ АЖ АХУЙ
ЭЗХЯ	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ



НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2026 оны 7 дугаар сарын байдлаарх макро эдийн засгийн төлөв байдал, төсвийн тодотгол хийх үндэслэл, төсөвт орсон өөрчлөлт

1.1. Олон улсын валютын сангийн төсөөллөөр дэлхийн эдийн засаг 2026 онд 3.0 хувь, 2027 онд 3.4 хувь, БНХАУ-ын эдийн засаг 2026 онд 4.6 хувь, 2027 онд 4.1 хувь, ОХУ-ын эдийн засаг 2026 онд 1.1 хувь, 2027 онд 1.1 хувиар өсөх төлөвтэй гэж тооцсон байна.¹

1.2. Монгол Улсын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд гадаад зах зээлийн эрэлт, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, экспортын гүйцэтгэлээс өндөр хамааралтай хэвээр байна. Эдийн засаг 2026 оны 7 дугаар сарын байдлаар 7.7 хувиар өссөн бол 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр өсөлт 5.7 хувь байхаар тооцсон байна. Эдийн засгийн 7.7² хувийн өсөлтийн 3.9 нэгж хувийг уул уурхай, 1.8 нэгж хувийг үйлчилгээ, 1.5 нэгж хувийг хөдөө аж ахуй, 0.5 нэгж хувийг аж үйлдвэрлэлийн салбар тус тус бүрдүүлсэн байна.

1.3. Монгол Улсын ДНБ 2026 оны 7 дугаар сарын байдлаар нэрлэсэн үнээр 52,486.0³ тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өссөн, инфляцын түвшин 13.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.9 нэгж хувиар нэмэгдэхэд дотоодын бараа, үйлчилгээ, ялангуяа хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

1.4. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2026 оны эхний хагас жилийн байдлаар 25.8 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 21.6 нэгж хувиар нэмэгдсэн бөгөөд банкны салбарын зээлийн үлдэгдэл 49,000.0 тэрбум төгрөгт хүрч, жилийн өсөлт 15.9 хувь болсон байна. Нийт зээлийн үлдэгдлийн 72.6 хувь буюу 35,540.0 тэрбум төгрөгийг бизнесийн зээл, 27.4 хувь буюу 13,417.0 тэрбум төгрөгийг хэрэглээний зээл бүрдүүлсэн байна.

1.5. Төлбөрийн тэнцэл 2026 оны эхний хагас жилийн байдлаар 567.0 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд уул уурхайн зарим түүхий эдийн үнэ болон экспортын биет хэмжээ өссөнтэй холбоотойгоор бараа, үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 4,330.0 сая ам.доллаар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Гадаад валютын улсын нөөц 2026 оны 7 дугаар сарын эцэст 7,963.0 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2,583.0 сая ам.доллаар өссөн байна.

1.6. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2026 оны эхний 7 сарын байдлаар 19,364.0 сая ам.долларт хүрч, экспорт 12,206.0 сая ам.доллар, импорт 7,158.0 сая ам.доллар болж, худалдааны тэнцэл 5,048.0 сая ам.долларын ашигтай гарсан байна. Экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний дундаж үнэ 69.2 ам.доллар/тн, зэс 13,149.0 ам.доллар/тн, алт 4,595.0 ам.доллар/унц, газрын тос 80.0 ам.доллар/баррель, төмрийн хүдэр 71.0 ам.доллар/тн байна. Нүүрсний экспортын биет хэмжээ 68.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 57.8 хувиар, зэсийн баяжмал 1,529.0 мянган тоннд хүрч, 23.0 хувиар тус тус өссөн байна⁴.

1.7. УИХ-аас 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр анх баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 33,479.5 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 33,479.5 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар баталжээ.

1.8. УИХ-аас 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 31,930.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.2 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 32,980.0

¹ Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд, 2026 оны 6-7 дугаар сар

² Сангийн яамны Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

³ ЭЗХЯ-ны Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

⁴ Сангийн яам, "Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл: батлагдсан, ЭЗХЯ-ны төсөөлөл, 2026 оны 7 сарын гүйцэтгэл"



тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.2 хувь, тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,050.0 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 1.0 хувьтай тэнцүү байхаар тус тус баталсан.

1.9. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 17,300.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 19,507.2 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 2,206.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

1.10. Нүүрсний экспорт нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлт харьцангуй тогтвортой байгаа ч геополитикийн нөхцөл байдлын нөлөөгөөр инфляц өсөж, газрын тосны үнэ өсөх, нийлүүлэлт буурах, бөөний болон жижиглэн худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил саарч байгаа нь аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагааг бууруулж, улмаар төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс буурахад нөлөөлсөн байна. Иймд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн өнөөгийн нөхцөл байдал, иргэдийн амьжиргаанд тулгамдаж буй асуудал, төсөвт учирч болзошгүй эрсдэлийг харгалзан төсвийн бодлогыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн уян хатан хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашиг, хэмнэлт, зарцуулалтын эрэмбэ, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх шаардлага бий болсон байна.

1.11. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлжээ.

1.12. Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан хүний эрх, эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөөг хангах, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, шударга өрсөлдөөнийг хамгаалах, технологи, инновацыг хөгжүүлэх, төрийн оролцоог зохистой түвшинд хязгаарлах, өсөлтийн үр өгөөжийг иргэдэд бодитоор хүртээх зорилгоор Засгийн газраас “Чөлөөлье” үндэсний санаачилгыг 2026 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэхээр баталсан байна. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь тус үндэсний санаачилгын үзэл баримтлал, зорилттой уялдуулж, тэвчиж болох зардлыг бууруулан, чөлөөлөгдсөн эх үүсвэрийг иргэдийн орлого, төрийн үйлчилгээ, эдийн засаг, нийгмийн нэн шаардлагатай дараах бодлогын арга хэмжээнд чиглүүлэн боловсруулжээ. Үүнд:

- Ахмад настны орлогын баталгааг нэмэгдүүлж, тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийг эхлүүлэх;
- Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсний зохицуулалтыг жигдрүүлж, салбар хооронд үүссэн цалингийн зөрүүг арилгах;
- “Гэрт ойрхон сургууль - хамгийн сайн сургууль” арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;
- Стратегийн зарим барааны нөөц, хангамжийг тогтворжуулах;
- Эрчим хүчний тарифыг нэмэгдүүлэхгүйгээр хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулах;
- Шатахууны нийлүүлэлтийг тогтворжуулж, үнийн өсөлтийг хязгаарлах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх;
- Төрийн өмчит компаниудын үр ашиг, төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг нэмэгдүүлэх;
- Төсвийн болон гадаад санхүүжилтийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Төрийн үйл ажиллагаанд хэмнэлт, таналт хийж чөлөөлье санаачилгын арга хэмжээг санхүүжүүлэх;
- Төсвийн шатлал хоорондын нэгдмэл байдлыг хангах.

1.13. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 31,930.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.2 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 33,978.0 тэрбум төгрөг буюу 33.2 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,048.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна.



1.14. Төсвийн тодотголоор төсвийн тэргүүлэх чиглэлийг дахин эрэмбэлж, ТЕЗ-дын батлагдсан төсөв хооронд зохицуулалт хийх, тухайн онд бодит үр дүн гарах боломж болон үр ашиг багатай зарим зардлыг бууруулах замаар урсгал зардлаас 433.4 тэрбум төгрөг, нийслэлийн үнэт цаасны санхүүжилтээс 758.0 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлаас 249.5 тэрбум төгрөг, нийт 1,440.9 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг иргэдийн орлого, нийгмийн хамгаалал болон төрийн үндсэн үйлчилгээнд дахин хуваарилахаар төлөвлөсөн байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2026 оны төсөвт тодотгол хийх эрх зүйн үндэслэл бүрдсэн байна

2.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7⁵ дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1⁶, 23.1.3⁷ дахь заалт, 23.2⁸ дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.6⁹, 9.2.3¹⁰ дахь заалтад тус тус зааснаар улсын төсвийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн батлахаар заасан.

2.2. Төсвийн тодотгол нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан нөхцөлөөс гадна хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилт, шалгуур үзүүлэлт, арга хэмжээ, төсөв, эх үүсвэрийн хэмжигдэхүйц байдлыг хангасан байх шаардлагатай¹¹.

2.3. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ТЕЗ-дын батлагдсан төсөв хооронд төсвийн зохицуулалт хийх, дахин хуваарилах зарчмаар Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4¹²-т заасны дагуу боловсруулсан байна.

2.4. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналтай уялдуулан УИХ-ын 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг УИХ-д өргөн мэдүүлсэн нь төсвийн удирдлагын зарчмыг алдагдуулахад хүргэж байна.

2.5. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ”, 7.4-т “Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүйгээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах, батлах болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхгүйгээр төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.6. Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн дагалдах хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй

⁵ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;

⁶ төсвийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх

⁷ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх

⁸ Энэ хуулийн 23.1-д заасан асуудлаарх Төсвийн тухай хуулийн 8.4.7-д заасан аудитын дүгнэлт, мөн хуулийн 8.4.8-д заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Улсын Их Хуралд ирүүлсэн даруйд гишүүдэд хүргүүлнэ.

⁹ Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жил бүрийн төсвийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн батална

¹⁰ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6-д заасан баримт бичигт нийцүүлэн батлах;

¹¹ Төсвийн тухай хуулийн 6.2.7

¹² төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх.



алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг бууруулан өөрчилж өргөн барьсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.

Төсвийн тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангаагүй байна

2.7. Төсөвт Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангахыг шаарддаг.

2.7.1. Төсвийн төсөл нь нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1¹³ дэх заалтын шаардлагыг хангасан байна.

2.7.2. Суурь тэнцэл ДНБ-ий хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байхыг шаарддаг бөгөөд 2026 оны төсвийн тодотголын тооцооллоор нэгдсэн төсвийн суурь тэнцэл 399.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.4 хувьтай байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан шаардлагад нийцээгүй байна.

2.7.3. Нэгдсэн төсвийн урсгал зарлага 26,054.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 25.4 хувьтай байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасан 30 хувийн дээд хязгаарыг хангасан байна.

2.7.4. Өрийн удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2¹⁴, 6 дугаар зүйлийн 6.3.1¹⁵, 17 дугаар зүйлийн 17.2¹⁶, 40 дүгээр зүйлийн 40.1¹⁷-д өрийн зохистой түвшнийг хангасан байхаар заасан бөгөөд төсвийн тодотголын төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийг ДНБ-ий 44.5 хувьтай байхаар тооцоолсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан 60 хувийн хязгаарыг хангасан байна.

Хүснэгт 1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд төсвийн тусгай шаардлагын нийцлийг үнэлсэн байдал

Хуулийн шалгуур	Үзүүлэлт	Тооцоо, /тэрбум төгрөг/	ДНБ-д эзлэх хувь	Хуулийн босго	Үр дүн	Тайлбар
ТБТХ 6.1.1	Тэнцвэржүүлсэн орлого	31,930.0	31.2%	Тэнцвэржүүлсэн журмаар	ХАНГАСАН	Зэс, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг ашигласан тооцоо ирүүлсэн.
ТБТХ 6.1.2	Суурь тэнцэл	399.9	0.4%	≥ 2.0% ашигтай	ХАНГААГҮЙ	Доод хэмжээнээс 1.6 хувиар доогуур.
ТБТХ 6.1.3	Урсгал зарлага	26,054.0	25.4%	≤ 30.0%	ХАНГАСАН	Хязгаараас 4.6 хувиар бага.
ТБТХ 6.1.4	Засгийн газрын өр	Төсвийн төсөөлөл	44.5%	≤ 60.0%	ХАНГАСАН	Хязгаараас 15.5 хувиар бага.

Эх сурвалж: Сангийн яам, Аудитын багийн тооцоолол

¹³ Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

¹⁴ өрийн зохистой түвшинг хангах;

¹⁵ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагыг хангасан байх;

¹⁶ Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагад нийцсэн байна.

¹⁷ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарыг нэрлэсэн дүнгээр тооцож, бүртгэнэ.



Төсвийн тодотголыг улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан байна

2.8. Төсвийн тодотголд орж буй голлох өөрчлөлтүүдийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцтэй байдлыг үнэллээ.

Хүснэгт 2. Төсвийн тодотголд орж буй өөрчлөлтийн бодлогын нийцлийн үнэлгээ

Өөрчлөлт	Урт хугацаа	Дунд хугацаа	Богино хугацаа /2026 он/	Үнэлгээ
Суурь тэтгэвэр	Хүний хөгжил, нийгмийн хамгаалал, амьдралын баталгаа, орлогын тэгш бус байдлыг бууруулах чиглэлтэй нийцнэ.	Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих нийгмийн хамгааллын шинэчлэлийн зорилготой нийцнэ.	Ахмад өрхийн орлогын бууралт, ядуурлын түвшин, хэрэглээний бүтэц, 435 мянган хүний дотор бодит дэмжлэг зайлшгүй шаардлагатай бүлгийн эзлэх хувь болон 2026 оны 11–12 дугаар сард бүх ахмадад олгохоор хугацааг 2 сар наашлуулна.	Урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн боловч богино хугацааны зорилт нь макро эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн тооцоо хангалтгүй.
Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг жигдрүүлэх	Эрүүл мэнд, боловсролын чанар, хүний хөгжил, төрийн үйлчилгээний хүртээмжийг дэмжинэ.	Төрийн үйлчилгээний чанар, хүний нөөцийн тогтвортой байдал, эрүүл мэнд, боловсролын салбарын чадавх нэмэгдүүлэх зорилготой уялдана.	Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсний зохицуулалтыг жигдрүүлж, салбар хооронд үүссэн цалингийн зөрүүг арилгана.	Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн нь үнийн өсөлтийн дарамт, инфляц нэмэгдэх эрсдэлтэй.
Гэрт ойрхон сургууль	Чанартай, хүртээмжтэй боловсролтой шууд нийцнэ.	боловсролын хүртээмж, сургалтын орчин, хотын хүн амын төвлөрөлтэй холбоотой үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилготой нийцнэ.	“Гэрт ойрхон сургууль - хамгийн сайн сургууль” арга хэмжээний хүрээнд 9.9 мянган суралцагч, 500 анги бүхий 22 сургуулийн байр түрээслэх	Төсвийн зарлага тэлэхэд нөлөөтэй.
Стратегийн хүнсний нөөц	Хүнсний хангамж, дотоодын үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангах бодлоготой нийцнэ.	Хөдөө, аж ахуй, нийлүүлэлтийн сүлжээ, инфляцын нийлүүлэлтийн шалтгааныг бууруулах бодлоготой уялдана	Стратегийн зарим барааны нөөц, хангамжийг тогтворжуулах хүрээнд 20 мян.тн мах, 100 мян.тн буудай, 12 мян.тн ногооны нөөц үүсгэх.	Төсвийн зарлага тэлэхэд нөлөөтэй.
Эрчим хүч	Найдвартай эрчим хүч, дэд бүтцийн зорилтыг дэмжинэ.	“Шинэ сэргэлт”-ийн эрчим хүчний сэргэлттэй шууд уялдана.	Эрчим хүчний тарифыг нэмэгдүүлэхгүйгээр хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулах зорилтын хүрээнд оргил ачаалал 12 дугаар сард 1,956 МВт хүрэх тооцоололтой.	Төсвийн зарлага тэлэхэд нөлөөтэй.

Эх сурвалж: Сангийн яам, Аудитын багийн тооцоолол

2.9. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг нийгмийн хамгаалал, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, боловсролын хүртээмж, стратегийн хүнсний нөөц, эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах чиглэлээр санхүүжилтийг нэмж төлөвлөсөн нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүний хөгжил, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хүнсний хангамж, эрчим хүч, дэд бүтцийн тогтвортой байдлыг хангах зорилтуудтай нийцэж байна. Тухайлбал,



- “Гэрт ойрхон сургууль-хамгийн сайн сургууль” арга хэмжээнд 50.0 тэрбум төгрөг нэмж тусган сургалтын зориулалтаар ашиглах боломжтой 22 байрыг түшиглэн 9.9 мянган хүүхдийн шинэ багтаамж бий болгох, 500 ангийн ачааллыг бууруулах, 32.7 мянган сурагчийн сургалтын орчныг сайжруулахаар төлөвлөсөн нь чанартай, хүртээмжтэй боловсролыг дэмжих урт болон дунд хугацааны бодлогын зорилгыг 2026 онд хэмжигдэхүйц үр дүнгээр хэрэгжүүлэхэд чиглэсэн байна;
- Мөн мах 20.0 мянган тонн, улаан буудай 100.0 мянган тонн, хүнсний ногоо 12.0 мянган тонны стратегийн нөөц бүрдүүлэх арга хэмжээ нь хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах урт хугацааны зорилго болон геополитик, нийлүүлэлтийн сүлжээ, үнийн өсөлтийн 2026 оны богино хугацааны эрсдэлийг бууруулах шаардлагатай уялдсан байна;
- Эрчим хүчний салбарт өвлийн оргил ачааллын үед 70-290 МВт хүртэл хэрэглээг хязгаарлах эрсдэл үүсэж болзошгүй нөхцөлд шинэ эх үүсвэр, батарей хуримтлуур, импортын нэмэлт эх үүсвэр, их засвар, шинэчлэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний сэргэлт болон эрчим хүчний найдвартай байдлыг хангах дунд хугацааны зорилттой шууд нийцэж байна.

2.10. Төсвийн тодотгол нь нэг талаас иргэдийн орлогыг хамгаалах, нийгмийн үйлчилгээ, хүнс, эрчим хүчний богино хугацааны эрсдэлийг бууруулах арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлсэн боловч нөгөө талаас урт, дунд хугацааны хөгжлийн чадавхыг бүрдүүлэх зарим хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зохион байгуулалтаас шалтгаалан хассан нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, хөгжлийн бодлогын зорилтот түвшин хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Төсвийн тодотгол нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байна

2.11 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.2.3 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 8.1, 12.3, 17.1 дэх хэсэг болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу төсвийн тодотгол нь үндэсний язгуур ашиг сонирхол, эдийн засаг, хүн ам, хүнс, эрчим хүч, байгаль орчин, мэдээлэл болон төрийн тогтолцооны аюулгүй байдлыг хангах бодлогын зорилттой нийцсэн, тэдгээрийн хэрэгжилтийг санхүүгийн эх үүсвэрээр баталгаажуулсан, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх төсөв, санхүүгийн эрсдэлийг зохих ёсоор тодорхойлж, үнэлж, бууруулах арга хэмжээг тусгасан байх шаардлагатай.

2.12. Төсвийн тодотголын голлох өөрчлөлтийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын холбогдох зорилттой тулган үзэхэд стратегийн хүнсний нөөц, эрчим хүчний өвөлжилт, эрүүл мэндийн үйлчилгээний тасралтгүй байдал, төсөв, санхүүгийн богино хугацааны эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь нийцлийн шаардлагыг хангаж байна.

2.13. Харин урсгал болон нийгмийн шилжүүлгийн зардлыг нэмэгдүүлсэн мөн төсвийн алдагдал хуульд зөвшөөрсөн дээд хязгаарт хүрсэн зэрэг нь урт хугацаанд эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй байна. Тухайлбал,

- Хүнсний нөөцийн хувьд ҮАБҮБ-ын 3.4.2.1-3.4.2.3¹⁸-т заасан тогтвортой хангамж, дотоодын үйлдвэрлэл, стратегийн нөөцийн зорилтыг нөөц бүрдүүлэх арга хэмжээ шууд дэмжсэн боловч хөдөө аж ахуйн техник, усалгаа, хадгалалт, боловсруулах үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг 20.1 тэрбум төгрөгөөр танасан нь дотоодын үйлдвэрлэлийн чадавхыг сулруулах, дунд хугацаанд хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж болзошгүй.
- Эрчим хүчний хувьд тоноглолын саатлаас 70-290 МВт хэрэглээ хязгаарлах эрсдэлийн эсрэг импортын тарифын зөрүүнд 107.3 тэрбум, их засвар, шинэчлэлд 92.7 тэрбум төгрөг тусгасан нь ҮАБҮБ-ын 3.2.1.2¹⁹-т нийцнэ. БНХАУ-аас нэмэлт 80 МВт импортлох нь түр арга хэмжээ

¹⁸ 3.4.2.1 хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх, 3.4.2.2 амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, 3.4.2.3 стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын болон улирлын нөөц бүрдүүлж хүнсний эрэлт, нийлүүлэлтийг тогтвортой байлгах

¹⁹ 3.2.1.2 эрчим хүчний салбарыг хүн амын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах стратегийн салбар



бөгөөд 3.2.4²⁰ -т заасан дотоодын эх үүсвэр, гадаад хамаарлыг бууруулах зорилтыг орлохгүй. Иймд импортын нэмэлт эх үүсвэрийг түр хугацааны эрсдэлийн арга хэмжээ гэж үзэж, дотоодын эх үүсвэр, дамжуулах сүлжээний хөрөнгө оруулалтыг сааруулахгүй байх шаардлагатай.

- Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг жигдрүүлэх 170.1 тэрбум төгрөг нь хүний нөөц, үйлчилгээний тасралтгүй байдлыг дэмжсэн боловч эрүүл мэндийн аюулгүй байдал нь зөвхөн хүний нөөц, цалингаас бус, оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, эмнэлгийн барилга, анхан шатны үйлчилгээний материаллаг чадавхаас хамаардаг. Ялангуяа орон нутагт анхан шатны тусламж, үйлчилгээний хөрөнгө оруулалтын санхүүжилт буурах нь үйлчилгээний чанар, хүртээмж, оношилгооны чадамжид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг харгалзан үзэх.
- Суурь тэтгэврийн хувьд ахмад настны орлогыг нэмэгдүүлж байгаа боловч хугацааг хоёр сараар наашлуулах хэрэгцээний судалгаа байхгүй, мөнгөн шилжүүлгийн инфляц, төгрөгийн худалдан авах чадварт үзүүлэх нөлөөг УАБҮБ-ын 3.2.3.4²¹, 4.1.5²²-ын хүрээнд үнэлээгүй.

2.14 Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.3.1-д “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл боловсруулна” гэж заасан.

Энэ асуудлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанаас тодруулга авахад Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажлыг хэрэгжүүлж байгаа талаар мэдээлсэн болно.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ОРЛОГО

3.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын төслийг боловсруулан, төлөвлөхдөө төрийн өмчит компаниудын үр ашгийг нэмэгдүүлж, шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлийг баримталсан байна.

3.2 Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийт орлого ба тусламжийн дүнг 2026 оны батлагдсан төсвөөс 918.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 36,172.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь ДНБ-ий 35.3 хувьтай тэнцэж байна. Үүнд: Татварын орлогыг 29,065.6 тэрбум төгрөг, татварын бус орлогыг 2,864.4 тэрбум төгрөг, Төсвийн тогтворжуулалтын санд 826.8 тэрбум төгрөг, Үндэсний баялгийн санд 3,415.4 тэрбум төгрөгийг хуримтлуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлт

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2026 он		Өөрчлөлт	
	Батлагдсан	Тодотгосон	Дүн	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	35,253.8	36,172.2	918.4	2.6
Тогтворжуулалтын сан	367.7	826.8	459.1	124.9
Үндэсний баялгийн сан	2,956.1	3,415.4	459.3	15.5
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	31,930.0	31,930.0	0.0	-
Татварын орлого	30,085.8	29,065.6	(1,020.2)	(3.4)
Татварын бус орлого	1,844.2	2,864.4	1,020.2	55.3

Эх сурвалж: Сангийн яам

²⁰ 3.2.4 эрчим хүчний дотоодын эх үүсвэрийг хөгжүүлж, гадаад хамаарлыг бууруулах

²¹ 3.2.3.4. Мөнгөний бодлогын үр дүнг дээшлүүлж, үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах, хөрвөх чадварыг сайжруулж, тогтворжуулна. Дотоодын гүйлгээ, төлбөр, тооцоонд зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтийг хэрэглэж, үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоодын зах зээлд эзлэх хувь, хэмжээг зохистой хэмжээнд байлгана.

²² 4.1.5. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа бүхэлдээ мэдээлэл, дүн шинжилгээнд суурилсан байх нөхцөлийг бүрдүүлж, аюулгүй байдлаа төр-ард түмний нэгдмэл хүчээр хангана.



3.3. Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлогыг 367.7 тэрбум төгрөгөөр баталсныг 459.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 826.8 тэрбум төгрөгт хүрэхээр тооцсон нь цэвэр зэсийн дундаж үнэ өмнөх оноос тонн тутам 38.0 орчим хувийн өсөлттэй байгааг үндэслэсэн байна.

3.4. Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх орлогыг 2,956.1 тэрбум төгрөгөөр баталсныг 459.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж тооцсон нь гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний экспорт, үнийн өсөлтөөс шалтгаалж АМНАТ-ийн орлогыг нэмж төлөвлөжээ.

3.5. Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнд 2026 оны батлагдсан төсвөөс өөрчлөлт оруулаагүй бөгөөд 31,930.0 тэрбум төгрөгөөр буюу ДНБ-ий 31.2 хувьтай тэнцэхээр төлөвлөсөн байна. Тэнцвэржүүлсэн орлогыг 2026 оны батлагдсан төсвөөс өөрчлөөгүй ч татварын орлогыг 3.4 хувиар бууруулж 29,065.6 тэрбум төгрөгөөр, татварын бус орлогыг 55.3 хувиар нэмэгдүүлж 2,864.4 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

Уул уурхайн салбарын орлого

3.6. Уул уурхайн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн баяжмалын биет хэмжээг нэмэгдүүлж, алт, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн экспортын биет хэмжээг бууруулж төлөвлөсөн байна.

3.7. Төсвийн орлого нь уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний үнэ, экспортын биет хэмжээнээс хамааралтай хэвээр байна.

Хүснэгт 4. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ

Д/д	Бүтээгдэхүүн нэр төрөл	Биет хэмжээ				Үнэ, ам доллар/нэгж			Орлого /тэрбум төгрөг/		
		х/н	2025 гүйц	2026		2025 гүйц	2026		2025 гүйц	2026	
				Бат	Тод		Бат	Тод		Бат	Тод
1	Нүүрс	сая.тн	90.0	90.0	100.0	64.1	70.0	70.0	4,373.8	4,907.1	4,525.0
2	Зэсийн баяжмал	сая.тн	2.3	1.9	2.2	9,938.6	9,700.0	12,700.0	3,697.5	2,933.5	3,986.3
3	Алт, тушаасан (цэвэр жингээр)	тн,\$/унц	11.3	20.0	10.1	3,429.2	2,800.0	4,500.0	579.9	519.2	855.0
4	Төмрийн хүдэр	сая.тн	8.8	9.4	9.2	72.1	69.0	70.0	457.8	317.2	302.0
5	Боловсруулаагүй нефть	сая.бар	3.5	3.8	3.5	71.3	72.0	80.0	231.9	232.0	254.3
6	Бусад								680.9	650.7	674.4
Дүн									10,021.8	9,559.1	10,597.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.8. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилахад ашиглах зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,341.8 ам.доллараар тооцсон бол зах зээлийн дундаж үнийг тонн тутамд 12,700.0 ам.доллараар төлөвлөсөн байна.

3.9. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд нүүрсний экспортын үнийг тонн тутамд 70.0 ам.доллараар тооцсон бөгөөд төсвийн тодотголоор уг үнийн төсөөллийг хэвээр хадгалсан байна. Нүүрсний экспортыг 2026 оны батлагдсан төсөвт 90.0 сая тонныг экспортлохоор төлөвлөснөөс 10.0 сая тонноор нэмэгдүүлсэн байна.

Татварын орлого

3.10. Татварын орлогыг 2026 оны батлагдсан дүнгээс 1,020.3 тэрбум төгрөгөөр бууруулж, 29,065.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Энэ нь гадаад үйл ажиллагааны орлогыг 403.7 тэрбум төгрөгөөр, онцгой албан татварыг 299.7 тэрбум төгрөгөөр, НӨАТ-ыг 266.0 тэрбум төгрөгөөр, орлогын албан татварыг 249.7 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж төлөвлөсөн нь голлон нөлөөлсөн байна.



Хүснэгт 5. Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын орлого

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2025 он	2026 он		Өөрчлөлт	
	Гүйц	Батлагдсан	Тодотгос он	Дүн	Хувь
Татварын орлого	27,213.0	30,085.8	29,065.6	(1,020.2)	(3.4)
Орлогын албан татвар	8,560.3	9,248.7	8,999.0	(249.7)	(2.7)
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	5,623.3	6,707.0	6,791.5	84.5	1.3
Хөрөнгийн албан татвар	609.8	626.9	514.8	(112.1)	(17.9)
Нэмэгдсэн өртгийн албан татвар	6,207.3	7,408.2	7,142.2	(266.0)	(3.6)
Онцгой албан татвар	949.0	1,331.5	1,031.8	(299.7)	(22.5)
Тусгай зориулалтын орлого	25.5	33.0	34.9	1.9	5.8
Гадаад үйл ажиллагааны орлого	1,842.2	2,255.0	1,851.3	(403.7)	(17.9)
Бусад татвар (төлбөр, хураамж)	3,395.6	2,475.5	2,700.0	224.5	9.1

Эх сурвалж: Сангийн яам

3.11. Татварын орлогын 31.0 хувийг орлогын албан татвар, 23.4 хувийг нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, 24.6 хувийг НӨАТ, 3.5 хувийг онцгой албан татвар, 6.4 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 1.8 хувийг хөрөнгийн орлого, 9.3 хувийг бусад татварын орлого тус тус эзэлж байна.

3.12. **Орлогын албан татварыг** 249.7 тэрбум төгрөгөөр бууруулж, 8,999.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь томоохон татвар төлөгчдийн ашиг, татвар ногдох орлого, татварын төлөлт буурсантай холбоотой байна.

- Монгол Улсын 2025 оны төсвийн орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 632.4 тэрбум төгрөгийн ААНОАТ-ыг урьдчилан төлүүлсэн нь 2026 онд төвлөрүүлэх орлогыг бууруулж, татварын орлого бүрдүүлэлтэд нөлөөлж байна.²³

3.13. **Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг** 344.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь цалин хөлсний нэмэгдэл, суурь тэтгэврийн нэмэгдлийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцсоноос шалтгаалжээ.

3.14. **Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг** 107.3 тэрбум төгрөгөөр нэмж төлөвлөсөн нь цалин хөлсний нэмэгдэл, төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

3.15. **Хөрөнгийн албан татварын орлогыг** 2026 оны батлагдсан төсвөөс 112.1 тэрбум төгрөгөөр бууруулж төлөвлөсөн нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 56.6 тэрбум төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 55.5 тэрбум төгрөгөөр тус тус бууруулснаас шалтгаалсан байна.

3.16. **Нэмэгдсэн өртгийн албан татвар орлогыг** 2026 оны батлагдсан төсвөөс 266.0 тэрбум төгрөгөөр бууруулж төлөвлөсөн нь импортын хэмжээ буурах төлөвтэй байгаагаас шалтгаалсан байна.

3.17. **Онцгой албан татварын орлогыг** 299.7 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн нь дотоодын архи, дарс, тамхины үйлдвэрлэл болон суудлын автомашины импортын хэмжээ буурсан нь нөлөөлсөн байна. Мөн Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1348 дугаар захирамжаар нийслэл хотод 10-аас дээш жилийн насжилттай суудлын автомашинд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгохгүй байхаар шийдвэрлэсэн байна.

3.18. **Гадаад үйл ажиллагааны татварын орлогыг** 403.7 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн нь Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбооны хооронд байгуулсан 3

²³ Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан: Нэгдсэн төсвийн нийт орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй, хэт өндөр төсөөлснөөс орлого тасарч, татвар төлөгчдөөс 1,247.9 тэрбум төгрөгийн татвар хураамжийг урьдчилан төлүүлж, тайлант оны гүйцэтгэлээр бүртгэж, тайлагнасан нь дараа оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд хүндрэл үүсгэхээр байна.



жилийн хугацаатай Худалдааны түр хэлэлцээр 2026 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж, импортын 356 нэр төрлийн бараанд ногдуулах гаалийн тарифыг бүрэн тэглэж, 6 нэр төрлийн бараанд 25-50 хувийн тарифын хөнгөлөлт, 5 нэр төрлийн бараанд квотын зохицуулалтыг хэрэгжүүлэх болсон, Засгийн газрын 2026 оны 328 дугаар тогтоолоор авто бензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2027 оны 8 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл тэглэсэн зэргээс шалтгаалжээ.

3.19. **Бусад татвар, төлбөр хураамжийн орлогыг** 224.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөсөн нь нүүрсний экспорт 53.9 хувиар, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 23.0 хувиар өмнөх оны мөн үеэс өссөн, дэлхийн зах зээл дэх зэсийн баяжмалын үнийн өсөлт зэрэгт үндэслэн АМНАТ-ийн орлогыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.20. Улсын төсвөөс 2026 онд аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 440.9 тэрбум төгрөгөөр баталсныг 28.2 хувь буюу 122.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 563.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмж төлөвлөсөнтэй холбоотой байна.

Татварын бус орлого

3.21. Татварын бус орлогын 88.8 хувийг нийтлэг татварын бус орлого, 0.2 хувийг хөрөнгийн орлого, 11 хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын бус орлого

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2025 он	2026 он		Өөрчлөлт	
	Гүйцэтгэл	Батлагдсан	Тодотгосон	Дүн	Хувь
Татварын бус орлого	3,090.2	1,844.2	2,864.4	1,020.2	55.3
Нийтлэг татварын бус орлого	2,734.6	1,473.2	2,543.4	1,070.2	72.6
Үүнээс: Хувьцааны ногдол ашиг	254.1	175.4	1,240.9	1,065.5	607.5
Хөрөнгийн орлого	9.9	6.0	6.0	-	-
Тусламжийн орлого	345.7	365.0	315.0	(50.0)	(13.7)

Эх сурвалж: Сангийн яам

3.22. **Хувьцааны ногдол ашгийн орлогыг** 1,065.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 1,240.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК (хуучнаар Эрдэнэс Монгол нэгдэл ХХК)-ийн 2025 оны татварын дараах цэвэр ашгаас 1,065.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлснээр татварын орлогын бууралтыг нөхөхөөр төлөвлөсөн байна.

- Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл баталгаажуулах аудитаар татварын бус орлогын төлөвлөгөөнд төрийн өмчит хуулийн этгээдүүдийн ашигт ажиллагаанаас нийт 100.0 тэрбум төгрөгийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг төлөвлөсөн боловч 21.8 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэр тодорхойгүй, ТӨБЗГ-ын 2025 оны 312 дугаар тогтоолоор 78.2 тэрбум төгрөгийг 31 хуулийн этгээдээс бүрдүүлэхээр баталснаас, 9 хуулийн этгээд 15.6 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн зөрчлийг таслан зогсоож, төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг бүрэн төвлөрүүлэх 2026 оны 1491/АО111371 дугаартай албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.
- Хувьцааны ногдол ашгийн орлого 2025 оны төлөвлөгөөнөөс 15.6 тэрбум төгрөг, 2026 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр 23.4 тэрбум төгрөгийг тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

3.23. **Навигацийн орлогыг** 21.0 тэрбум төгрөгөөр бууруулж 19.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь Засгийн газрын 2026 оны 309 дүгээр тогтоолын дагуу “МИАТ” ТӨХК-ийн орон нутгийн нислэгийн алдагдлыг тус орлогоос санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн нь нөлөөлсөн байна.

3.24. **Газрын тосны орлогыг** 22.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 254.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь нэгж баррель тосны үнэ өссөнөөс шалтгаалсан байна.



ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ЗАРЛАГА

4.1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг батлагдсан төсвөөс 998.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 33,978.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Төсвийн тодотголоор нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 76.7 хувь буюу 26,054.0 тэрбум төгрөгийг урсгал зардал, 24.8 хувь буюу 8,414.4 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал, 1.4 хувь буюу (490.4) тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Хүснэгт 7. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн нийт зардлын үзүүлэлт

/тэрбум төгрөг/

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн нийт зардлын үзүүлэлт	2026 он		Өөрчлөлт
	Батлагдсан	Тодотгол	
Улсын төсвийн зардал	22,885.1	23,977.7	1,092.6
ОН-ын төсвийн зардал	7,330.1	7,332.4	2.3
Нийгмийн даатгалын сан	6,517.5	6,713.8	196.3
Эрүүл мэндийн даатгалын сан	2,383.3	2,462.7	79.4
Төсөв хоорондын шилжүүлэг	(6,136.0)	(6,508.6)	(372.6)
Дүн	32,980.0	33,978.0	998.0

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн хавсралт.

4.2. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд урсгал зардлыг 433.4 тэрбум төгрөгөөр, нийслэлийн үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжих зардлыг 758.0 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 249.5 тэрбум төгрөгөөр нийт 1,440.9 тэрбум төгрөгийг бууруулахаар тусгасан байна.

4.3. Урсгал зардлаас бууруулахаар төлөвлөсөн 433.4 тэрбум төгрөгөөс 216.9 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвийн бусад хөрөнгийн зардлаас, 216.5 тэрбум төгрөгийг улсын төсвийн урсгал зардлаас бууруулахаар тооцож, чөлөөлөгдөх эх үүсвэрийг дахин хуваарилах замаар шаардлагатай зардлыг нэмэгдүүлэн төлөвлөхөөр тооцсон байна.

Төсвийн урсгал зардал

4.4. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн урсгал зардлыг 24,901.9 тэрбум төгрөгөөр баталснаас Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр нийт урсгал зардлыг 1,152.1 тэрбум төгрөгөөр буюу 4.6 хувиар нэмэгдүүлж, 26,054.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 8. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын үзүүлэлт

/тэрбум төгрөг/

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын үзүүлэлт	2026 он		Өөрчлөлт	
	Батлагдсан	Тодотгол	Дүн	Хувь
Улсын төсвийн урсгал зардал	18,570.0	19,962.0	1,392.1	7.5
ОН-ын урсгал зардал	3,424.4	3,281.3	(143.1)	(4.2)
Нийгмийн даатгалын сан	6,584.8	6,781.1	196.3	3.0
Эрүүл мэндийн даатгалын сан	2,458.7	2,538.2	79.5	3.2
Төсөв хоорондын шилжүүлэг	(6,136.0)	(6,508.6)	(372.6)	6.1
Дүн	24,901.9	26,054.0	1,152.1	4.6

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн хавсралт

4.5. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд улсын төсвийн урсгал зардлыг 1,392.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь голлон



нөлөөлсөн байна. Мөн Нийгмийн даатгалын сангийн урсгал зардлыг 196.3 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн урсгал зардлыг 79.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, орон нутгийн урсгал зардлыг 143.1 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

4.6. Монгол Улсын 2026 оны улсын төсвийн урсгал зардлын төсөв, тодотгосон дүнгийн өөрчлөлтийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр хүснэгтээр харуулав.

Хүснэгт 9. Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлын харьцуулалт

№	ТЕЗ	2026 он		Өөрчлөлт	
		Батлагдсан	Тодотгол	Дүн	Хувь
1	БОЛОВСРОЛЫН САЙД	4,397.4	5,020.9	623.5	14.2
2	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	112.1	311.9	199.8	178.3
3	САНГИЙН САЙД	2,530.4	2,696.7	166.3	6.6
4	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	483.2	628.8	145.6	30.1
5	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	4,727.4	4,872.9	145.6	3.1
6	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	1,764.4	1,850.4	86.0	4.9
7	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	677.2	703.9	26.8	4.0
8	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	316.3	320.9	4.6	1.5
9	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	177.7	181.9	4.3	2.4
10	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	19.0	21.2	2.2	11.7
11	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	222.4	224.1	1.7	0.8
12	Бусад ТЕЗ	3,142.5	3,128.4	(14.1)	(0.4)
Нийт дүн		18,570.0	19,962.0	1,392.1	7.5

Эх сурвалж: Сангийн яам

4.7. Засгийн газрын 2026 оны 285 дугаар тушаалаар батлагдсан “Чөлөөлье” үндэсний санаачилгын үзэл баримтлалд тусгагдсан зорилтын хүрээнд төсвийн тодотголоор улсын төсвийн урсгал зардлыг төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсний зохицуулалтыг жигдрүүлж, салбар хооронд үүссэн цалингийн зөрүүг арилгах зорилгоор 671.8 тэрбум төгрөгөөр, төрийн өмчит болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 537.5 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын урсгал шилжүүлгийг 214.6 тэрбум төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 13.3 тэрбум төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 92.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бусад зардлыг 137.6 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн байна.

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал

4.8. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2026 оны батлагдсан төсвөөс 687.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 7,687.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 10. Монгол Улсын 2026 оны цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын нэгдсэн төсвийн үзүүлэлт

Монгол Улсын 2026 оны цалингийн зардлын нэгдсэн төсвийн үзүүлэлт	2026 он		Өөрчлөлт	
	Батлагдсан	Тодотгол	Дүн	Хувь
Улсын төсөв	6,410.9	7,082.7	671.8	10.5
Орон нутгийн төсөв	581.0	594.9	13.9	2.4
Нийгмийн даатгалын сан	0.1	0.1	-	-
ЭМ-ийн даатгалын сан	8.7	10.2	1.5	17.2
Дүн	7,000.7	7,687.9	687.2	9.8

Эх сурвалж: Сангийн яам



4.9. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2026 оны батлагдсан төсвөөс 10.5 хувь буюу 671.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 7,082.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардлыг салбараар

/тэрбум төгрөг/

Салбар	Батлагдсан төсвөөс нэмэгдүүлж төсөвлөсөн дүн			Тайлбар
	Цалингийн зардал	НДШ зардал	Нийт дүн	
Боловсролын салбар	592.4	82.5	674.9	Дутагдсан цалингийн зардал
Эрүүл мэндийн салбар	10.8	1.5	12.3	Салбарын цалинг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 20 хувь нэмэгдүүлэх
Соёл, спорт, бусад төрийн үйлчилгээний салбар	84.0	10.3	94.3	Салбарын цалинг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 50 хувь нэмэгдүүлэх
Цалингийн дүн	687.2	94.3	781.5	

4.10. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт болон төрийн үйлчилгээний бусад салбарын цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн нь төрийн үйлчилгээний чанар, ажиллах хүчний тогтвортой байдлыг хангах эерэг нөлөөтэй боловч урсгал зардлын тооцооллыг салбар тус бүрийн орон тоонд үндэслэсэн нэгдсэн тооцоо, судалгаагаар баталгаажуулаагүй байна. Мөн эдгээр зардлууд нь 2027 оноос төсөвт байнгын шинжтэй ачаалал үүсгэхээр байгаа тул санхүүжилтийн хэрэгцээ, төсвийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцож, орон тоо, цалингийн бодит хэрэгцээнд үндэслэн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох шаардлагатай байна.

Татаас ба урсгал шилжүүлэг

4.11. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төсвийн нөөцийг дахин хуваарилж улсын төсвөөс эрчим хүч, нийгмийн даатгал, хүнс, хөдөө аж ахуйн салбаруудад 537.5 тэрбум төгрөгийн татаасыг нэмж олгохоор төлөвлөсөн байна.

4.12. Төсвийн тодотголоор нэмэгдүүлж төлөвлөсөн татаасын 73.7 хувь буюу 396.0 тэрбум төгрөгийг төрийн өмчит байгууллагад олгох татаас, 26.3 хувь буюу 141.5 тэрбум төгрөгийг хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгох татаас

/тэрбум төгрөг/

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлт	2026 он		Өөрчлөлт	
	Батлагдсан	Тодотгол	Дүн	Хувь
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,725.9	2,121.9	396.0	22.9
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	31.0	231.0	200.0	645.2
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	1,664.9	1,861.2	196.3	11.8
БОЛОВСРОЛЫН САЙД	0.4	0.1	(0.3)	(70.0)
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	9.9	9.9	-	-
САНГИЙН САЙД	7.9	7.9	-	-
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	4.5	4.5	-	-
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	3.8	3.8	-	-
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	2.6	2.6	-	-
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	0.9	0.9	-	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	395.7	537.2	141.5	35.8
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	328.8	478.1	149.3	45.4
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	18.5	12.5	(6.0)	(32.3)



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	1.9	0.9	(1.0)	(52.6)
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	1.2	0.9	(0.3)	(25.0)
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	1.3	0.8	(0.5)	(38.5)
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	20.1	20.1	-	-
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	23.9	23.9	-	-
Нийт дүн	2,121.6	2,659.1	537.5	25.3

Эх сурвалж: Сангийн яамны мэдээгээр

4.13. Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.17-д “хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах” гэж заасныг үндэслэн ОХУ, БНХАУ-аас импортын цахилгаанаар хангах, цахилгааны үнэ, тарифын алдагдалд 107.3 тэрбум төгрөг, төрийн өмчит компаниудын дулааны цахилгаан станцууд, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний их засварт 92.7 тэрбум төгрөг, нийт 200.0 тэрбум төгрөгийн татаас олгохоор төлөвлөсөн байна.

4.14. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлд заасны дагуу суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгож, шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгахаар зохицуулсан ч хэрэгжилтийн хугацааг наашлуулж, 2026 оны 11-12 дугаар сард ахмадуудад суурь тэтгэвэр нэмж олгоход шаардагдах 196.3 тэрбум төгрөгийн татаасыг нэмж олгохоор төлөвлөсөн байна.

4.15. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хувийн хэвшлийн байгууллагуудад олгох татаас зардлыг 141.5 тэрбумаар нэмэгдүүлж 537.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

4.16. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад тусгасан мах, улаан буудай, хүнсний ногооны хангамж тогтворжуулалтын зардалд 150.0 тэрбум төгрөгийг нэмэгдүүлж, арьс шир, ноосны урамшуулал зардлыг 0.7 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн байна.

4.17. Хүнсний стратегийн нөөцийг бүрдүүлэх, хүн амын хүнсний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, зах зээл дэх үнийн огцом өсөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэмэгдүүлэн төлөвлөсөн 150.0 тэрбум төгрөгийн татаасыг дараах арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөжээ. Үүнд:

- Улаан буудайн стратегийн нөөц бүрдүүлэхээр 2026 оны намрын ургацаас 62.0 мянган тонн, хүнсний улаан буудай худалдан авахад 80.7 тэрбум төгрөг;
- Төмс, хүнсний ногооны хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулах, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд худалдан авалтын зардалд 26.5 тэрбум төгрөг, стандартын шаардлага хангасан агуулахад нөөцийг хадгалах зардалд 4.2 тэрбум төгрөг, нийт 30.7 тэрбум төгрөг;
- Ургац хураалтын ажлыг тогтвортой явуулах, шатахууны хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор шатахууны нөөц /дизель түлш/ бүрдүүлэхэд 24.6 тэрбум төгрөг;
- Гурилын дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүн амын гурилын хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гурил үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох улаан буудай худалдан авах зориулалтаар зээл олгоход Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгийн 2026 оны 9-12 дугаар сарын гүйцэтгэлд 3.8 тэрбум төгрөг, нийслэлийн хүн амын хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэхэд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгт 10.2 тэрбум төгрөг, нийт 14.0 тэрбум төгрөг;



4.18. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд урсгал шилжүүлгийн зардлыг батлагдсан төсвөөс 45.7 тэрбум төгрөгөөр бууруулан 12,889.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 13. Урсгал шилжүүлгийн зардлын харьцуулсан дүн

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2025 оны төсөв	2025 оны гүйцэтгэл	2026 оны төсөв	2026 оны тодотгол	Өөрчлөлт			
					Өмнөх оны гүйцэтгэлээс	Хувь	2026 оны төсвөөс	Хувь
Улсын төсөв	5,743.6	5,476.8	6,103.4	6,241.1	764.3	14.0	137.7	2.3
Орон нутгийн төсөв	2,050.4	1,473.1	1,576.3	1,417.5	(55.6)	(3.8)	(158.8)	(10.1)
Нийгмийн даатгалын сангийн төсөв	5,868.1	5,847.6	6,583.4	6,779.6	932.0	15.9	196.2	3.0
ЭМД-ын сангийн төсөв	2,229.2	2,228.9	2,445.7	2,523.4	294.5	13.2	77.7	3.2
Төсөв хоорондын шилжүүлэг	(3,778.4)	(3,261.3)	(3,773.3)	(4,071.8)	(810.5)	24.9	(298.5)	7.9
Нийт дүн	12,112.9	11,765.2	12,935.5	12,889.8	1,124.6	9.6	(45.7)	(0.4)

Эх сурвалж: Сангийн яам

4.19. Улсын төсвөөс урсгал шилжүүлгийн зардлыг эрүүл мэндийн салбар болон бусад салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, улсын төсвөөс аймгуудад олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүжилттэй холбоотой 137.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

4.20. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр суурь тэтгэврийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ээс буюу анх батлахдаа хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн хугацаанаас өмнө хэрэгжүүлэхэд шаардлагатай 196.2 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсөвт тусгасан байна.

4.21. Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-нд 30.0 хувь нэмэгдүүлсний 2026 онд дутагдах эх үүсвэр болон 2026 оны 11 дүгээр сарын 01-ээс дахин 20.0 хувь нэмэгдүүлэхтэй холбоотой 77.7 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

4.22. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг батлагдсан төсвөөс 2.0 хувиар буюу 13.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж нийт 671.5 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсөв

4.23. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг Засгийн газрын 2026 оны “Чөлөөлье” үндэсний санаачилгыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 285 дугаар тогтоолд “Гэрт ойрхон сургууль-хамгийн сайн сургууль” төсөл, арга хэмжээний хүрээнд нийслэлийн ачаалал өндөртэй байршлуудад 9.9 мянган суралцагчийг хамруулах сургуулийн зориулалттай 22 барилга түрээслэхээр төлөвлөж 13.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөжээ.

4.24. “Гэрт ойрхон сургууль-хамгийн сайн сургууль” арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг төлөвлөхдөө Боловсролын сайд, Сангийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зориулалттай барилга түрээслэх жишиг үнийн дээд хязгаар тогтоох тухай” тушаалд заасан жишиг үнийн хязгаарт нийцүүлж төлөвлөх шаардлагатай байна.



Санхүүжилтийг түр зогсоох зардлын төсөв

4.25. Засгийн газрын 2026 оны 325 дугаар тогтоолоор төсвийн зарцуулалтыг хэмнэлтийн горимд шилжүүлэх, төсвийн сахилга бат, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах зорилгоор зарим урсгал зардлын санхүүжилтийг түр зогсоохоор шийдвэрлэсэн боловч төсвийн тодотголоор ТЕЗ-ийн холбогдох зардлыг харилцан адилгүй бууруулан төлөвлөсөн байна.

4.26. Тухайлбал, улсын төсвийн нийт 36 ТЕЗ-дын томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас 19 ТЕЗ-дын 1.2 тэрбум төгрөгийн зардлыг бууруулахаар төлөвлөсөн бол төрийн өндөр албан тушаалтны урьдчилан төлөвлөгдсөн албан ёсны гадаад томилолтын зардалд хамаарахгүй зарим ТЕЗ-дын зардлыг бууруулаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2026 оны 325 дугаар тогтоолын 1.2-т заасан санхүүжилтийг түр зогсоох арга хэмжээг төсвийн тодотголд бүрэн тусгаагүйг харуулж байна.

4.27. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд зарим зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор судалгаа хийж, үр дүнг тусгасан. Тухайлбал, төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх 24 хороо, зөвлөл, ажлын албаны үйл ажиллагаанд 17.5 тэрбум төгрөг, гадаад албан томилолтод 74.3 тэрбум төгрөг, хэвлэл мэдээллийн ажил, үйлчилгээнд 22.3 тэрбум төгрөг, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд 61.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Иймд гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, урсгал засвар, багаж, техник хэрэгсэл, тавилга, эд хогшил худалдан авах зардлын төлөвлөлтийг ТЕЗ тус бүрээр дахин нягталж, өмнөх аудитын дээрх судалгааны үр дүнг үндэслэн бууруулах боломжтой зардлыг тооцон төсвийн тодотголд тусгах шаардлагатай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн

4.28. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7, 22 дугаар зүйлийн 22.6.4²⁴-т заасны дагуу нэгтгэн тусгасан бөгөөд төсвийн тодотголоор урсгал зардлын чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг шинэчлэн боловсруулаагүй байна.

Иймд урсгал зардлын чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг төсвийн тодотголын тооцоололтой уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал

4.29. Засгийн газраас 2026 оны 8 дугаар сарын 20-нд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилийн санхүүжилтийг 249.5 тэрбум төгрөг буюу 7.6 хувиар бууруулахаар төлөвлөжээ.

²⁴ төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;



Хүснэгт 14. Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалт

/тэрбум төгрөг/

Ангилал	Батлагдсан			Тодотгол			Өөрчлөлт /хасахаар төлөвлөсөн/		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	605	9,959.4	2,569.0	581	8,952.1	2,462.4	24	1,007.3	106.6
Их засвар	24	322.5	99.6	22	312.3	96.4	2	10.2	3.1
Тоног төхөөрөмж	93	778.0	570.1	88	502.6	450.7	5	275.4	119.4
ТЭЗҮ	10	46.9	28.4	8	27.1	17.6	2	19.8	10.8
Цахим систем	6	36.0	13.1	3	4.1	3.5	3	31.9	9.6
Нийт	738	11,142.8	3,280.2	702	9,798.3	3,030.7	36	1,344.6	249.5

4.30. Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн тодотголын төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг 249.5 тэрбум төгрөгөөр бууруулж төлөвлөхдөө дараах өөрчлөлтүүдийг тусгажээ. Үүнд:

Хэмнэлтэд тооцож хасахаар болон санхүүжилтийг зогсоохоор 272.5 тэрбум төгрөг:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй 32 төсөл, арга хэмжээний 118.6 тэрбум төгрөг;
- Багцад хуваарилсан боловч гэрээ байгуулаагүй багцын задаргаа төсөл, арга хэмжээний 103.3 тэрбум төгрөг;
- Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тендерийн хэмнэлт 29.4 тэрбум төгрөг;
- Тухайн онд хэрэгжих боломжгүй болон шүүхийн маргаантай 4 төсөл, арга хэмжээний 21.2 тэрбум төгрөг;

Санхүүжилтийг нэмэгдүүлэхээр 23.0 тэрбум төгрөг:

- Мянганы сорилтын сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн Монголын талын хөрөнгө оруулалтад 2025 онд төлөвлөсөн хөрөнгөөс санхүүжүүлээгүй үлдэгдэл болох 23.0 тэрбум төгрөгөөр 2026 оны санхүүжилтийг нэмэгдүүлэхээр тус тус төлөвлөжээ.

4.31. Тухайн жилийн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах эдгээр өөрчлөлтүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1²⁵, 13.1.2²⁶, 13.1.3²⁷ дахь, Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.7²⁸ дахь заалт болон Мянганы сорилтын компакт гэрээгээр хүлээсэн үүрэг, зорилтод нийцэж байна.

4.32 Төсвийн тодотголын төслөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас хасахаар төлөвлөсөн 272.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн 81.4 хувь буюу 221.9 тэрбум төгрөг нь хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүйгээс шалтгаалан хэмнэлтэд тооцохоор тусгагджээ. Үүнд улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтаар шинээр эхлүүлэх 296 төсөл, арга хэмжээний 155 төсөл, арга хэмжээ буюу 52.4 хувь нь УИХ-аар төсвийн төслийг хэлэлцэх явцад нэмж батлагдсан, тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байсан нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй 32 төсөл, арга хэмжээний хэмнэлтэд тооцох 118.6 тэрбум төгрөгийн 83.6 хувь нь буюу 99.2 тэрбум төгрөгийн 21 төсөл, арга хэмжээ нь хэлэлцүүлгийн явцад нэмж батлагдсан;

²⁵ 13.1.1. “Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах”

²⁶ 13.1.2. “Энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох”

²⁷ 13.1.3. “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”

²⁸ 32.2.7. “Санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар”



- Багцад хуваарилсан боловч гэрээ байгуулаагүйгээс хэмнэлтэд тооцогдох 103.3 тэрбум төгрөгийн 49.7 хувь буюу 51.3 тэрбум төгрөг нь хэлэлцүүлгийн явцад нэмж батлагдсан төслүүдээс үүссэн байна.

4.33. Төсвийн төслийг хэлэлцэх явцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар зарчмын зөрүүтэй санал гаргасан тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан байхаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.7.3²⁹ дахь заалтад тусгасан байна.

4.34. Хэлэлцүүлгийн явцад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээ нь хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан эсэхийг хэн хэрхэн хянах, шаардлага хангаагүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний зохицуулалт Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тодорхой тусгагдаагүй байна.

4.35. Энэ нь төсвийн төслийг байнгын хороодоор болон Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэх явцад эдийн засгийн үр ашиг, нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, өртөг зардлын судалгаа тооцоогүй, баталгаажсан зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад нэмэгдэж батлагдах эрсдэлийг дагуулж, цаашлаад хуулийн хугацаанд худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж дуусгахад сөргөөр нөлөөлж байна.

4.36. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлах зөрчил давтагдан гарч байгаад анхаарал хандуулж, төсвийн төслийг хэлэлцэх, батлах явцад зарчмын зөрүүтэй санал гарч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж тусгах, хэлэлцүүлэх тохиолдолд төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хэн хэрхэн хянах талаарх зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгах шаардлагатай байна.

ТАВ. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

5.1. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 31,930.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.2 хувь, нийт зарлагын хэмжээг 33,978.0 тэрбум төгрөг буюу 33.2 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,048.0 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувь байхаар төлөвлөжээ. Батлагдсан төсвөөс нийт орлогыг 918.4 тэрбум төгрөг буюу 2.6 хувиар, нийт зарлагыг 998.0 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар нэмж төсвийн тодотголыг боловсруулсан байна.

Хүснэгт 15. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2026		Өөрчлөлт
	Батлагдсан	Тодотгосон	
НИЙТ ОРЛОГО	35,253.8	36,172.2	918.4
Тогтворжуулалтын сан	367.7	826.8	459.1
Үндэсний баялгийн сан	2,956.1	3,415.4	459.3
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	31,930.0	31,930.0	-
НИЙТ ЗАРЛАГА	32,980.0	33,978.0	998.0
Урсгал зардал	24,901.9	26,054.0	1,152.1
Хөрөнгийн зардал	8,568.5	8,414.4	(154.1)
Эргэж төлөгдөх цэвэр зээл	(490.4)	(490.4)	-
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	(1,050.0)	(2,048.0)	(998.0)³⁰

²⁹ 71.7.3. "Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар төсвийн төслийн ... хэлэлцүүлэг явуулах үед гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, нам, эвслийн бүлгийн гаргасан санал нь ... Төсвийн тухай хуулийн ... 29.4-т нийцсэн байх ... шаардлагыг хангасан байна"

³⁰ Орон нутгийн төсвийн урьд оны ашиглаагүй үлдэгдлийг зарцуулахтай холбоотойгоор нэгдсэн төсвийн нийт зарлага болон тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 998.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.



ДНБ-д эзлэх хувь	-1.0%	-2.0%	-1.0%
СУУРЬ ЗАРЛАГА	29,859.1	31,530.1	1,671.0
ДНБ-д эзлэх хувь	29.2%	30.8%	1.6%
СУУРЬ ТЭНЦЭЛ	2,070.9	399.9	(1,671.1)
ДНБ-д эзлэх хувь	2.0%	0.4%	-1.6%

Эх сурвалж: Сангийн яам

5.2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 998.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2,048.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9-д заасан ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гэсэнтэй нийцэж байна.

ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР

6.1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 31,930.0 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн зарлагыг 33,978.0 тэрбум төгрөгөөр тооцож, төсвийн тэнцлийг 2,048.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар 2026 оны төсвийн тодотголын төслийг боловсруулжээ.

Хүснэгт 16. Нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн тодотгол

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2026		Өөрчлөлт
	Батлагдсан	Тодотгосон	
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,930.0	31,930.0	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)	32,980.0	33,978.0	998.0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	(1,050.0)	(2,048.0)	(998.0)
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,050.0	2,048.0	998.0
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	(22.9)	(542.7)	(519.8)
2. Засгийн газрын үнэт цаас	1,484.6	1,811.5	326.9
2.1. Урт хугацаат	1,484.6	1,811.5	326.9
2.1.1. Дотоод	595.6	1,680.6	1,084.9
2.1.1.1. Шинээр гаргах	901.3	1,986.2	1,084.9
2.1.1.2. Үндсэн төлбөр	(305.7)	(305.7)	-
2.1.2. Гадаад	889.0	131.0	(758.0)
2.1.2.1. Шинээр гаргах	1,545.5	787.5	(758.0)
2.1.2.2. Үндсэн төлбөр	(656.6)	(656.6)	-
3. Засгийн газрын зээл	(411.7)	779.2	1,190.9
3.2. Гадаад	(411.7)	779.2	1,190.9
3.2.1. Төслийн зээл	299.8	299.8	-
3.2.1.1. Шинээр авах	1,235.3	1,235.3	-
3.2.1.2. Үндсэн төлбөр	(935.5)	(935.5)	-
3.2.2. Хөтөлбөрийн зээл	(711.5)	479.4	1,190.9
3.2.2.1. Шинээр авах	-	1,190.9	1,190.9
3.2.2.2. Үндсэн төлбөр	(711.5)	(711.5)	-

6.2. Нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал санхүүжүүлэх эх үүсвэрийг Засгийн газрын дотоод үнэт цаас 1,986.2 тэрбум төгрөг, гадаад үнэт цаас 787.5 тэрбум төгрөг, Засгийн газрын гадаад төслийн зээл 1,235.2 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээлээс 1,190.9 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлж, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 305.7 тэрбум төгрөг, гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 656.6 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 1,647.0 тэрбум төгрөг төлөхөөр тооцоолон төсвийн тодотголд тусгасан байна.

6.3. Засгийн газрын шинээр гаргах 1,986.2 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасны 425.0 тэрбум төгрөгийн үнэт цаас нь орон нутагт гаргах үнэт цаас, 1,561.2 тэрбум төгрөг нь Засгийн газрын дотооддоо гаргах үнэт цаас байна. Орон нутагт гаргах дотоод үнэт цаасыг Засгийн газрын 2026 оны 49, 267 дугаар тогтоолуудын дагуу НЗДТГ-т 275.0 тэрбум төгрөг, Засгийн газрын



2025 оны 43 дугаар тогтоолын дагуу Өмнөговь аймгийн ЗДТГ 150.0 тэрбум төгрөгөөр гаргахаар тус тус шийдвэрлэсэн байна.

6.4. Засгийн газар 2026 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар нээлттэй хэлбэрээр 170.0 тэрбум төгрөг, хаалттай хэлбэрээр 300.0 тэрбум төгрөг, нийт 470.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас гаргаж, нэмэлтээр 226.2 тэрбум төгрөгийн нээлттэй үнэт цаас, 865.0 тэрбум төгрөгийн хаалттай дотоод үнэт цаасыг тус тус гаргахаар төлөвлөсөн байна.

6.5. Улсын Их Хурлын 2025 оны “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” 102 дугаар тогтоолд тусгасан Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах хэмжээг 1,000.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 1,561.2 тэрбум төгрөг болгон өөрчлөхөөр Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн байна.

6.6. Улсын Их хурлын 2024 оны 17 болон Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолуудаар “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах” төсөлд зориулж 500.0 сая ам.долларыг 7.75 хувийн хүүтэй 2.8 жилийн хугацаатай гаргасан гадаад үнэт цаасны 2026 онд санхүүжих 1,545.5 тэрбум төгрөгийн арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 758.0 тэрбум төгрөгөөр бууруулж, 787.5 тэрбум төгрөгөөр тодотгосон байна.

6.7. Төсвийн тодотголд Азийн хөгжлийн банкнаас төлбөрийн тэнцэл болон гадаад валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулах, төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд зориулан 200.0 сая ам.доллар, байгалийн аюулт үзэгдэл, эрүүл мэндийн онцгой нөхцөл байдал болон эрчим хүч, хүнсний хангамжтай холбоотой онцгой нөхцөл үүсэх үед авах хариу арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрт зориулан 125.0 сая ам.доллар, нийт 1,190.9 тэрбум төгрөгийн гадаад хөтөлбөрийн зээлийг шинээр авахаар төлөвлөжээ.



ДОЛОО. ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 31,930.0 тэрбум төгрөгөөр, нийт зарлагын дээд хэмжээг 33,978.0 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,048.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тооцсон байна;
2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудаас 6.1.1, 6.1.3, 6.1.4 дэх заалтуудыг хангасан боловч 6.1.2-т заасан суурь тэнцэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх шаардлагатай нийцээгүй нь хуулийн 6.1-д заасан тусгай шаардлагууд нь “нэгэн зэрэг” хангасан байх шаардлагыг хангаагүй байна;
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн дагалдах хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг бууруулан өөрчилж, өргөн барьсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгтэй зөрчилдөж байна;
4. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зорилт хангагдахгүй байх, ач холбогдол буурах, төсвийн удирдлагын зарчмыг алдагдуулахад хүргэж байна;
5. Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголд тусгасан өөрчлөлтүүд нь үндэсний аюулгүй байдал болон хөгжлийн бодлогын зорилттой нийцэж байгаа боловч нийгэм, эдийн засгийн богино хугацааны эрсдэлийг бууруулах хүрээнд урсгал зардлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бууруулсан нь төсвийн зарлагын бүтцийг өөрчилж, дунд, урт хугацаанд төсвийн болон үнийн тогтвортой байдлыг хадгалахад эрсдэл үүсгэж болзошгүй байна;
6. Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, суурь тэтгэврийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн нь өрхийн орлого, эдийн засгийн дотоод эрэлтийг нэмэгдүүлэх нөлөөтэй хэдий ч инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Иймд цалин, тэтгэврийн нэмэгдлээс үүдэх төсвийн зарлагын өсөлтийн инфляцад үзүүлэх нөлөөллийг тооцож, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах нь зүйтэй байна;
7. Татварын орлогыг бууруулан төлөвлөхөд Засгийн газрын 2026 оны 328 дугаар тогтоолоор автобензин, дизелийн түлшний хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулах, хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварыг 0 хувь болгон тогтоосон, томоохон татвар төлөгчдийн ашиг, татвар ногдох орлого, татварын төлөлт, импортын хэмжээ буурсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна;
8. Аж ахуйн нэгж байгууллагын 2026 оны орлогын албан татварыг 2025 онд урьдчилан төвлөрүүлсэн нь тухайн онд төвлөрүүлэх орлогыг бууруулж, татварын орлогын бүрдүүлэлтэд нөлөөлсөн байна;
9. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК (хуучнаар Эрдэнэс Монгол нэгдэл ХХК)-ийн 2025 оны татварын дараах цэвэр ашгаас 1,065.5 тэрбум



- төгрөгийн ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлснээр татварын орлогын бууралтыг нөхөхөөр төлөвлөсөн байна;
10. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар тухайн жилийн төсвийн тухай хуулиар тогтоосон ногдол ашгийн орлогыг дутуу төвлөрүүлж байгаа нь татварын бус орлого бүрэн бүрдэхгүй байх нөхцөлийн бүрдүүлж байна. Тухайлбал, Аудитаар өмнөх онд дутуу бүрдүүлсэн ногдол ашгийн орлого 15.6 тэрбум төгрөгийг бүрэн төвлөрүүлэх, эх үүсвэр тодорхойгүй 21.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлого төлөвлөсөн зэрэг зөрчлийг таслан зогсоох, зөрчил дахин давтан гаргахгүй байх (2026 оны 1491/АО111371 дугаартай) албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна;
 11. Төсвийн тодотголын төсөлд ахмад настны орлогыг дэмжих, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн зөрүүг арилгах, хүнс, эрчим хүчний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөхдөө нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг нэмэгдүүлэхгүйгээр нийт зарлагыг 998.0 тэрбум төгрөгөөр өсгөж, төсвийн алдагдлыг 2,048.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий хоёр хувьд хүргэхээр төлөвлөсөн нь төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй тохиолдолд төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх эрсдэлтэй байна;
 12. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд урсгал зардлын чиглэлээр баримтлах бодлого, зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг хэмжих чанарын болон тоон үзүүлэлтийг тусгаагүй, шинэчлэн боловсруулаагүйгээс төсвийн тодотголоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, төсвийн зарцуулалтын үр нөлөө, үр ашгийг үнэлэхэд хүндрэл үүсэх эрсдэлтэй байна;
 13. Төсвийн хэлэлцүүлгийн явцад нэмж төлөвлөж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхэд тавих хяналт, зохицуулалт хангалтгүй байгаа нь хуулийн хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулахад сөргөөр нөлөөлж, хөрөнгө оруулалтад төлөвлөсөн санхүүжилтийн үр ашгийг бууруулж байна;



Хавсралт 1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө

/сая төгрөгөөр/

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч		2026 он		Зөрүү	Өөрчлөлтийн хувь
			Батлагдсан	Тодотгосон		
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга		185.0	185.0	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0	185.0	-	-
2	Монгол Улсын Их Хурлын дарга		100.0	100.0	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0	100.0	-	-
4	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга		510.0	510.0	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0	510.0	-	-
5	Монгол Улсын Ерөнхий сайд		85,422.8	1,150,909.4	1,065,486.6	12.5
	1	Төсөвт төвлөрүүлэх	81,600.0	1,147,099.0	1,065,499.0	13.1
	2	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,822.0	3,810.4	(12.4)	(0.0)
6	Монгол Улсын Шадар сайд		20,872.8	20,064.8	(808.0)	(0.0)
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	20,872.8	20,064.8	(808.0)	(0.0)
7	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга		300	300.0	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	300	300.0	-	-
8	Гадаад харилцааны сайд		6,100.00	9,100.0	3,000.0	(0.0)
	1	Төсөвт төвлөрүүлэх	6,000.00	6,000.0	-	-
	2	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.00	3,100.0	3,000.0	30.0
9	Сангийн сайд		19,064,084.1	18,763,828.0	(300,256.1)	(0.0)
	1	Төсөвт төвлөрүүлэх	18,692,058.5	17,615,012.4	(1,077,046.1)	(0.1)
	1.1	Үүнээс: Тогтворжуулалтын санд	367,653.5	826,790.0	459,136.5	1.2
	2	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	7,025.6	7,025.6	-	-
	3	Тусламжийн орлого	365,000.0	315,000.0	(50,000.0)	(0.1)
10	Хууль зүй, дотоод хэргийн сайд		64,847.1	64,847.1	-	-
	1	Төсөвт төвлөрүүлэх	27,800.0	27,800.0	-	-
	2	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	35,994.6	35,994.6	-	-
	3	ЭМДС-гаас улсын эмнэлгүүдэд олгох	1,052.5	1,052.5	-	-
11	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд		2,209.7	2,209.7	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,209.7	2,209.7	-	-
12	Батлан хамгаалахын сайд		42,760.7	42,760.7	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	42,760.7	42,760.7	-	-
13	Боловсролын сайд		5,534.8	5,534.8	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,534.8	5,534.8	-	-
14	Зам, тээврийн сайд		72,300.0	53,300.0	(19,000.0)	(0.3)
	1	Төсөвт төвлөрүүлэх	40,300.0	19,300.0	(21,000.0)	(0.5)
	2	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	32,000.0	34,000.0	2,000.0	0.1



15	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд		339,573.9	460,692.5	121,118.6	0.4
	1	Төсөвт төвлөрүүлэх	294,146.9	415,265.5	121,118.6	0.4
	2	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	45,427.0	45,427.0	-	-
16	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд		55,974.8	57,787.7	1,812.9	0.0
	1	Төсөвт төвлөрүүлэх	1,500.0	3,500.0	2,000.0	13
	2	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	51,866.8	51,679.7	(187.1)	(0.0)
	3	ЭМДС-гаас улсын эмнэлгүүдэд олгох	2,608.0	2,608.0	-	-
17	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд		39,143.3	39,012.7	(130.6)	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	39,143.3	39,012.7	(130.6)	-
18	Эрүүл мэндийн сайд		9,032.7	8,998.4	(34.3)	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	9,032.7	8,998.4	(34.3)	-
19	Төрийн албаны зөвлөлийн дарга		200	200.0	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	200	200.0	-	-
20	Монгол Улсын Ерөнхий аудитор		831.3	-	(831.3)	(1.0)
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	831.3	-	(831.3)	(1.0)
21	Санхүүгийн зохицуулах хорооны дарга		4,002.9	4,002.9	-	0.0
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,002.9	4,002.9	-	0.0
22	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд		284.0	158.9	(125.1)	(0.4)
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	284.0	158.9	(125.1)	(0.4)
23	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд		13,918.4	8,964.6	(4,953.8)	(0.4)
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	13,918.4	8,964.6	(4,953.8)	(0.4)
24	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд		8,588.6	8,549.5	(39.1)	(0.0)
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,588.6	8,549.5	(39.1)	(0.0)
25	Монгол Улсын Шадар сайд		115.9	115.9	-	-
	1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	115.9	115.9	-	-

Эх сурвалж: Сангийн яам

Хавсралт 2. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл

/тэрбум төгрөг/

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл		Тодотгол			Зөрүү		
					Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2026	2027	2028	2026	2027	2028	2026	2027	2028
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.7	6.3	6.5	5.7	5.8	6.0	-	(0.5)	(0.5)
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.0	5.0	8.0	7.0	6.0	1.0	1.0	1.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	31,930.0	33,761.0	37,299.3	31,930.0	34,780.0	37,371.8	-	1,019.0	72.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.2	29.3	28.2	31.2	30.4	29.4	-	1.1	1.2
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	32,980.0	34,626.0	37,829.2	33,978.0	36,493.4	38,644.0	998.0	1,867.4	814.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.2	30.0	28.6	33.2	31.9	30.4	1.0	1.9	1.8
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(1,050.0)	(865.0)	(529.9)	(2,048.0)	(1,713.4)	(1,272.2)	(998.0)	(848.4)	(742.3)
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	(1.0)	(0.8)	(0.4)	(2.0)	(1.5)	(1.0)	(1.0)	(0.7)	(0.6)
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	29,859.1	31,452.6	33,254.6	2,647.0	2,515.4	2,150.6	(27,212.1)	(28,937.2)	(31,104.0)
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	29.2	27.3	25.1	2.6	2.2	1.7	(26.6)	(25.1)	(23.4)
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	2,070.9	2,306.0	2,646.0	8,568.5	8,962.6	9,032.6	6,497.6	6,656.6	6,386.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	2.0	2.0	8.4	7.8	7.1	6.4	5.8	5.1
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	51,200.0	51,885.0	59,535.0	51,200.0	57,114.9	63,610.1	-	5,229.9	4,075.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	50.0	45.0	45.0	50.0	50.0	50.0	-	5.0	5.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,664.3	2,774.1	2,909.4	2,664.3	2,823.0	2,998.2	-	48.9	88.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.6	2.4	2.2	2.6	2.5	2.4	-	0.1	0.2

Хавсралт 3. Төсвийн ерөнхийлөн захирагчдын тодотгосон нийт зардал

/тэрбум төгрөг/

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	2026 он		Зөрүү	Өөрчлөлтийн хувь
		Батлагдсан	Тодотгол		
1	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	30.5	30.4	(0.1)	(0.3)
2	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	145.4	144.3	(1.2)	(0.8)
3	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	362.4	367.0	4.6	1.3
4	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	102.6	97.2	(5.4)	(5.3)
5	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	206.6	202.0	(4.5)	(2.2)
6	САНГИЙН САЙД	3,611.1	3,750.3	139.2	3.9
7	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	739.5	766.3	26.8	3.6
8	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	1,988.0	2,045.0	57.0	2.9
9	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	5.3	5.1	(0.2)	(3.5)
10	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	28.8	28.7	-	-
11	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	283.8	285.5	1.7	0.6
12	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	141.7	141.8	0.1	0.0
13	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	42.5	42.2	(0.2)	(0.5)
14	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	49.8	49.8	-	-
15	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	28.1	27.9	(0.2)	(0.6)
16	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	20.7	20.7	-	-
17	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	14.2	13.6	(0.6)	(4.0)
18	ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	1.1	1.1	-	-
19	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	351.4	349.9	(1.6)	(0.4)
20	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	26.0	26.0	-	-
21	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	10.5	10.3	(0.2)	(2.1)
22	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	51.5	51.3	(0.2)	(0.4)
23	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	385.5	377.7	(7.7)	(2.0)
24	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	1,497.3	1,486.4	(10.9)	(0.7)
25	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	250.8	240.1	(10.7)	(4.3)
26	БОЛОВСРОЛЫН САЙД	4,787.1	5,377.6	590.5	12.3
27	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	1,028.1	982.0	(46.1)	(4.5)
28	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	95.8	94.2	(1.6)	(1.7)
29	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	557.2	672.1	114.9	20.6
30	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	424.7	604.7	180.1	42.4
31	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	4,795.7	4,940.5	144.8	3.0
32	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	511.0	456.8	(54.2)	(10.6)
33	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	213.9	198.6	(15.3)	(7.2)
34	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	85.7	79.7	(6.0)	(7.0)
35	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	5.2	5.2	-	-
36	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	5.8	5.6	(0.2)	(4.2)
37	ОРОН НУТАГ	7,330.1	7,332.4	2.3	0.0
38	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН	6,517.5	6,713.8	196.3	3.0
39	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН	2,383.3	2,462.6	79.4	3.3
40	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	(6,136.0)	(6,508.6)	(372.5)	6.1
	Нийт дүн	32,980.0	33,978.0	998.0	3.0

Эх сурвалж: Сангийн яам